



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/25

Мөрөн сум

“Хог пресслэх байр” барих ажлын явцад
хяналт тавих, хүлээн авах комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2025 оны 03 сарын 27-ний өдрийн А/51 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2025 оны 04 сарын 25-ний өдрийн 04 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1.Иргэн Э.Дашдаваа нь сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих “Хог пресслэх байр” барих ажлын тендерт ялж 2025 оны 05 сарын 06-ний өдрөөс 2025 оны 06 сарын 20 -ний дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлын явцад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хүлээн авах сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Комиссын дарга:	Г.Хишигбаатар	Хууль эрх зүйн мэргэжилтэн
Гишүүдэд:	Ө.Өнөрөө	Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан
	Д.Ганцэцэг	Улсын бүртгэгч
	Б.Бямбадорж	Байгаль хамгаалагч
	А.Энхтөр	Нярав

2.Иргэн Э.Дашдаваагаас хүлээн авах “Хог пресслэх байр”-ыг барих ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн өнгө үзэмж, тоо хэмжээ, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (Г. Хишигбаатар) -д үүрэг болгосугай.

3.“Хог пресслэх байр”-ыг Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэж авахын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

НАМЖИЛНОРОВ

234150125